

ᠲᠥᠮᠥᠷᠯᠦᠭᠢᠨ ᠤᠷᠯᠠᠯ

ТӨМӨРЛӨГИЙН УРЛАЛ





АГУУЛГА

ЗОРИЛГО: Төмөрлөгийн урлалийн талаар таних мэдэх .

МЭДЛЭГ: Монгол дархны урлал, зориулалт

БАТАТГАЛ: Ур хийцийн ялгааны тухай асуулт

ДҮГНЭЛТ: Дархан хүн бурхан ухаантай

ДАРХАН ХҮН

Монголчууд бид эрт үеэс Дархан хүн бурхан ухаантай хэмээн ярьж, нутаг хошуугаараа, хүн зоноороо хүндэтгэсээр ирсэн билээ. Уран дархан хүн ямар ч түүхэн цаг хугацааны үед чухал байр суурь эзэлсээр иржээ. Дархчуудаараа нутгийн бэл бэнчинтэй айлууд, ард иргэд эмээл, хазаар, бүс, мөнгөн аяга, дээлийн товч, эр хүний малгайн гоёл, бүсгүй хүний гоёл чимэглэл гээд бүхий л үнэт эдлэл, хэрэглэлээ хийлгэсээр иржээ.



Дархан хүнийг тэнгэрээс харж, аливаа муу үйлээс хамгаалдаг хэмээн учир мэдэх хүмүүс ярьцгаадаг. Учир нь Дархан хүнийг шарын талаас Данжин, бөөгийн талаас Дорлиг хэмээх бурхдууд хамгаалдаг ажээ. Мөн тэдний шүтээн нь алх, дөш нь бөгөөд, цагаан сараар уран дархан хүн дөшөө хойморь өөдөө залж хадгаар ороож, цагаан идээ, шар тосоор идээ засдаг байна.

Үүнээс харахад дархан хүн алх, дөшөө хэрхэн дээдэлдгийг мэдэж болох юм.



ЦЭЭР

Харин алх, дөшний сүнс нь бөөрөндөө байдаг учир тэд хажуу талаар нь юм цохихыг тун цээрлэдэг аж. Мөн дөшөө гадны хүн тохойлдохыг хориглодог бөгөөд тохойлдвол дөшний нүдүүлдэг зовлонг тохойлдсон хүн үүрдэг хэмээн ярьцгаадаг.



Металын шинж чанар

Өнгөт металл нь халаагаад хөргөхөд
уян болдог.

Хар металл нь халаагаад хөргөхөд
хатуурч ган орж байдаг.





ТӨМӨРЛӨГИЙН УРЛАЛЫН АНГИЛАЛ

Төмөрлөгийн урлалыг хэрэглэж байгаа багаж төхөөрөмж материал, хийцээр нь **Дархны ба Уран дархны** гэж хоёр ангилдаг

ТӨМӨРИЙН ДАРХАН

Хүрлийн үе бол манай эриний өмнөх 4-2 мянган жилийн үеийг хамардаг. Энэ үед хүрэл урлал, төмрийн урлал хөгжиж, хүрэл хутга, хүрэл даруулга, хүрэл унжлага, араатны толгойн хүрэл дүрс, хүрэл тогоо, төмөр анжис, төмөр хутга, хазаарын амгай, оломны төмөр арал зэргийг хийж байжээ.

Төмрийн дархны ажилд ямааны арьсаар хийсэн тулман хөөрөг, модоор хийсэн авдран хөөрөг, лантуу, алх, дөш, хасуур, цоолтуур, чимхүүр зэргийг хэрэглэдэг.

Орчин үед дархны ажлаар тулга, цоож, галын хайч, хазаарын амгай, шөвөг, оломны арал, хутга, ооль түүнчлэн техникийн төрөл бүрийн эд ангиуд хийж байна. Ийм ажил хийдэг хүнийг **төмрийн дархан** гэж нэрлэдэг.





Уран дархны урлалын зориулалт

Гоёл чимэглэлийн

Хүний хэрэгцээнд зориулсан:

Ээмэг, бөгж, зүүлт, бугуйвч, товч, хонх, эхнэр хүний толгойн чимэг, мөнгөн бүс, хормойн боолт, мөнгөн аяга, хэт хутга гэх мэт

Малд зориулсан:

Эмээл, хазаар, ташуурын тоног

Бурхан шашны


Зэс алтаар хийсэн бурхан, цөгц, тахилын зүйлс



Ахуйн хэрэгцээний

Хувин, сав суулга, домбо, аяга, шанага, гэх мэт





XVII зууны үеийн шашин, нийгмийн зүтгэлтэн, Анхдугаар Богд Жавзундамба хутагт бурханы шашин, урлаг, соёлын нэрт зүтгэлтэн Г. Занабазарын бүтээсэн 21 Дарь эх, суварга, Язгуурын бурхад зэрэг бүлтээлүүдээ хөөх, сийлэх, цутгах арга техникүүдийг ашиглан уралсан нь монголд төдийгүй дэлхийд алдартай уран нарийн дахин давтагдашгүй бүтээл гэдгээрэй алдаршиж байна.



Дундговь аймгийн төмөрийн дархад
олон түлхүүртэй монгол цоож сайн
хийж урладгаараа алдартай байжээ.



Төв аймгийн уран дархад
эмэгтэй хүний толгойн гоёл чимэглэлийг уран
нарийн чамин хийдгээрэй алдартай.



Монгол уран дархан гэдэг хэзээнээсээ гарын ур дүй сайтай, ухаан уужим хүмүүс байжээ. Үүнийг эртний уран дархчууд болоод одоогийн зарим уран дархчуудын бүтээл, аж амьдралаас харж болно. Дархан хүн гэдэг багажаа өөрийн гараар хийж, хийсэн бүтээл, эд зүйл нь чанартай он удаан жил эзэндээ эдлэгдэхийн зэрэгцээ, гоёмсог хээ угалзаар чимэглэсэн, тун чамбай бүтээлүүд байдаг билээ. Энэ олон уран дархдын дотроос бусдаасаа өөрийн өвөрмөц хийцээр ялгаран гайхагдаж олон даяар алдаршиж байгаа хийцүүд бол **Батноров, Дарьганга, Далайчойнхор, Ноён сэврээ, Боржигон, Буриад хийц** гэгдэж нутаг нутгийн аж ахуй зан заншил, хэв маяг харуулсан дахин давтагдашгүй бүтээлүүд төрөн гарсаар байна.



Ноён сэргээ хийц: Хуучнаар Балдан засгийн хошуу одоогийн Өмнөговь аймгийн Сэргэй сумын мөнгөн эдлэлийн хийц мөнгөн аяга нь ихэд алдаршиж, нэрд гарсан байна. Ноён сэргэйн сургуулийн хийцийн мөнгөн аяга дотор, ёроол хэсгийг их орцтой мөнгөөр хийж, бүдүүн мөнгөн утсаар давхарлан, хаж тавьж битүү бад хээгээр чимэглэн урласан байдаг. Мөн аяганы ёроолыг бусад хийцийн ёроолтой харьцуулахад илүү дэлбэгэр хийдгээс гадна мөнгө түлхүү оруулж өгдөг онцлогтой байна.





Батноров хийц: Уг хийцийн гол онцлог нь хээний зурлага цохилгоог голдуу эвэр угалз барьж цутгахдаа давтамж хэмийг толин тусгалаар бус харин сөөлжүүлсэн байршлаар сүлжин тиглэдэг байна. Өөр нэг онцлог нь таван лан мөнгөнд нэг лан гууль баримталсан цутгуурын хэвээ “цой” загварт эвэр угалзны эргэлтийн дагуу орон зайн шийдлээр зөвхөн хажиж зааглаж урладаг байна. Мөн хээ чимгээ тал харагдах бус бүтэн нүд дүүрэн харагдах байдлаар урладаг байна.



Дарьгага хийц: Модоор сийлбэрлэх, цаасаар эвхэж хайчлах аргаар үндсэн эх зураг, загварыг зохион бүтээж, зузаан мөнгөн дээр цаасан хэвээр тортогдон, цалин цагаан мөнгөөр хөөн товойлгох давхардуулан сүлжээлэн ухаж, цоолборлон сийлж ухаж, урлан бүтээх маягийг дарьганга хийц гэдэг байна. Энэ хийцэд мөнгө их ордог бөгөөд том том шүрэн болон эрдэнийн чулуун шигтгээтэй буюу гол дүрслэлийг алт өргөн тодруулж урладагаараа нэн онцлогтой төдийгүй ихэс язгууртны тансаг хэрэглээнд ихээхэн хэрэглэдэг байжээ.

Далайчойнхор хийц: Энэхүү хийц нь ихэд алдартай, нэрд гарсан ган сийлбэр юм. Ган дээр хээ чимгийг сийлж алтаар цувцайлдаж, мөнгөөр жижүүддэг нь уг сургуулийн хийцийн шийдэл юм. энэ хийцийн сийлбэр нь өнгөлгөө сайтай учир он цаг хэдий элээсэн ч элэгдэж, зэвэрч, муудаж, хат нь хардаггүй нь тухайн хийцийн чансааг, урын онцлогийг тодруулдаг байна.



Боржигон хийц: Боржигон хийцэд дархны урлагийн бүхий л арга барилыг хэрэглэх боловч гол арганы хөөмөл цутгуурын арга юм. Боржигон хийцийн мөнгөн хөөмөл, сийлбэрийн ирмэг хөвөөг урлахдаа эвэр, зартиг, хажлах уран сайхны илэрхийллийн аргыг алхам тутамдаа баримтлах ба аяганы ёроолын хүнхэрт үүлэнд умбан хөдөлдөг луу, хэт хутга, бэл бүхий дүрслэлийг оруулдаг байна.



БАТАТГАЛ

1. ТӨМРИЙН ДАРХАН БОЛОН УРАН ДАРХНЫ ЯЛГАА
2. БАТНОРОВ ХИЙЦИЙН ЯЛГАА
3. СУРАГЧ БҮР УРАН ДАРХНЫ НЭГ ХИЙЦИЙГ СОНГОН
АВЧ ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛЖ
СУДАЛГАА ХИЙХ



ДҮНГЭЛТ

Монгол хүн хаана ч явсан хүний аяга халбага, хутга хэргэлдэггүй. Тэдгээрийг айл хооронд ч аян жинд ч биендээ авч явна. Ариун цэврийн хэрэглэл болох сахлын чимхүүр, хэлний хусуур, тамхины иж бүрэн хэрэглэлээ мөнгөөр дахин давтагдашгүй гоёмсог хийцээр урлуулан өдөр тутам хэрэглэн иржээ.

Монгол дархны багаж дундаас хамгийн эрхмийг нь ноён гурван багаж гэж нэрлэдэг.

Үүнд алх, дөш, хайч ордог бөгөөд дархнаас өөр хүн хүрэх ёсгүй нарийн нандин ёс цээртэй байдаг тул хүүхдүүд та бүхэн хамаагүй хүрч болохгүй байна шүү .

МОНГОЛ ДАРХНЫ БАГАЖ

